



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

### “Улаанбаатар травэл экспо-2023” Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, нийслэлийн Засаг даргын 05 дугаар сарын 01-ний өдрийн А/419 дугаар захирамж, Газрын дүрмийн 4.1.3, 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт бараа бүтээгдэхүүн нийлүүлж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг нэг цэгээс хэрэглэгчидтэй уулзуулж, аялагч, амрагчдад аяллын талаарх мэдээ, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Улаанбаатар травэл экспо-2023” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн арга хэмжээг 2023 оны 05 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд Мишээл Экспо-д зохион байгуулсугай.

2. Арга хэмжээг зохион байгуулах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 35 945 860 /гучин таван сая есөн зуун дөчин таван мянга найман зуун жаран/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Уянга/-д зөвшөөрсүгэй.

4. Арга хэмжээ зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Ажлын хэсэг /В.Батчимэг/-г даалгасугай.

ДАРГА *D. Batm* Д.БАТСҮХ



1150500140

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2023 оны 05 сарын 16 өдрийн  
А/А/ дугаар тушаалын хавсралт

“УЛААНБААТАР ТРАВЭЛ ЭКСПО-2023” ОЛОН УЛСЫН АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ҮЗЭСГЭЛЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Үзэсгэлэнгийн талбайн түрээс	1	6 000 000	6 000 000
2	Видео хийх	1	1 500 000	1 500 000
	Бүүст -хийх	1	1 000 000	1 000 000
4	Үзэсгэлэн арга хэмжээний талбайн үндсэн тохижилт	1	6 000 000	6 000 000
5	Хөтлөгчийн зардал	1	500*3	1 500 000
6	Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийг ажиллуулах бүүт тохижуулах	1	4 000 000	4 000 000
7	Цайны замын олон улсын аялал жуулчлалын холбооны гадаад зочдын зочид буудлын зардал	10/3өдөр	523 000	5 235 860
8	Гадаад зочдын тээврийн зардал	3/3өдөр	570 000	1 710 000
9	Цайны замын олон улсын аялал жуулчлалын холбооны хурлын танхим	1	2 000 000	2 000 000
10	Олон улсын аялал жуулчлалын холбооны гадаад зочдын хоолны зардал	25хүн*2өдөр	100 000	5 000 000
<b>Дүн</b>				<b>35 945 860</b>

--- оОо ---